




ЧИ
ДУРЛАХИХСАН
БОЛОХООР

ЭСВЭЛ
ЗҮГЭЭР Л
ХӨГЖИЛТЭЙ
ТОГЛООМ
БАЙСАН БОЛОХООР



ЭСВЭЛ ЧАМА
СОНГОЛТ
БАЙХГҮЙ ЮМ
ШИГ
САНАГДСАН
УЧРААС,



АЛБ Ч ТОХИОЛДОЛД ЧИ СЕХТ ЗУРВАС ХЭН НЭГЭН РҮВ ЯВУУЛАХДАА ЗӨВХӨН ТА ХОЁРЫН ДУНД ҮЛЭЭНЭ ГЭЖ БОДСОН БАЙХ. ГЭТЭЛ ТЭГСЭНГҮЙ.

ХЭРЭВ ЦЛГЭЭГҮЙ БОЛ.



ЦЛГЭЭД ЧИНИЙ ЗУРАГ
ЭСВЭЛ ВИДЕО
ЦАХИМА ТАРЧИХЛАА

ХАРИН ЧИ ЮУ ХИЙХ
ЁСТОЙГОО
МЭДЭХГҮЙ БАЙГАА.



ҮНЭЭС БОЛЖ
БҮСАА ХҮМҮҮС
ЧАМАЙГ

ШҮҮМЖИЛЖ,
ДОРМЖИЛНО
ГЭХЭЭС,



ЭСВЭЛ
ЭЦЭГ, ЭХ
ЧИНБ
УУРЛАЖ,
УРАМ НБ

ХУГАРНА ГЭХЭЭС
САНАА ЧИНБ
ЗӨВЖ,

ЭНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛДАС ГАРАХ ГАРЦГҮЙ МЭТ САНАГДАЖ БОЛНО.

ГЭХДЭЭ ГАРЦ ҮРГЭЛЖ БАЙДАГ.

ХИЙСЭН ҮЙЛДЛЭЭ
БУЦААХ
БОЛОМЖГҮЙ Ч
ДАРДАХ
ДЛХМУУДЫГ
ХИЙГЭЭРЭЙ

- ★ ЦАХИМ ОРЧНООС ЗУРАГ, БИЧЛЭГЭЭ УСТГАХ, УСТГУУЛАХ
- ★ ЦААШАА НЭМЖ ТАРХААС СЭРГИЙЛЖ ТУСЛАМЖ ХҮСЭХ
- ★ СЭТГЭЛЗҮЙН ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ ХҮСЭХ
- ★ БУСААДС ЦРЭХ ДЭЭРЭЛХЭЛТ, ДОРМЖЛОЛЫГ ДАВАН ТУУЛАХ

НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОН ӨӨРИЙНХӨӨ АМЬДРАЛЫГ ГАРТАА ЭРГҮҮЛЭН АВААРАЙ.



ГОМДОЛ ГАРГАХ!



Lantuun Dohio

UNITED AGAINST CHILD ABUSE & HUMAN TRAFFICKING

Энэ бол чиний зөвшөөрөлгүйгээр хувийн зураг, бичлэгийг чинь цахим орчинд тараасан тохиолдолд авах хамгийн чухал алхмуудын нэг юм.

Дараах газруудад мэдэгдэж болно:

• Тухайн сайт ба апп руу

Найдвартай сайт ба аппууд хүүхдийн нүцгэн зураг, бичлэг нийтлэгдэхээс сэргийлж ажилладаг ба хэрэв тэр тухай гомдол хүлээн авбал цаг алдалгүй олж устгадаг. Мөн чиний зургийг зөвшөөрөлгүйгээр түгээсэн хүний цахим хаягийг мэдээлээрэй. Түгээмэл ашиглагддаг олон нийтийн сүлжээнүүдэд хэрхэн гомдол гаргах талаар илүү дэлгэрэнгүйг мэдээллийг NCMEC.org/GetHelpNow-рүү зочилон авч болно.

• CyberTipline.org-руу мэдэгдэх

Энэхүү гомдол хүлээн авах шугам нь асуудлыг чинь шийдвэрлэхэд хамгийн тохиромжтой мэргэжилтнүүдтэй чамайг холбож өгнө. Тэд чиний өмнөөс тухайн сайт эсвэл харьяа цагдаагийн газартай холбогдон асуудлыг мэдэгдэхээс гадна хэрэв хэргийг шийдвэрлэхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол чамтай холбоо барина. Чи гомдол гаргахдаа нэрээ нууцалж болох бөгөөд хэрэв найздаа тусалж буй бол найзынхаа өмнөөс мэдэгдэж болно.

• Цагдаад мэдэгдэх

Цагдаа тухайн дүрс бичлэг, зургийг цахим орчинд цааш тархыг зогсоох ба тэдгээрийг дамжуулж буй хүмүүсийн үйлдлийг таслан зогсоож чадна.

• Багшдаа мэдэгдэх

Хэрвээ дүрс бичлэг, зураг чинь сургуулийн орчинд тарсан бол багш болон сургуулийн захиргаанаас тэдгээрийг цааш түгээх нь хариуцлагад татагдах үйлдэл гэдгийг бусад сурагчдад ойлгуулж өгч болно.

ТУСЛАМЖ АВАХ!

Ийм асуудалд орсон үед бүх асуудалтай чи ганцаараа нүүр тулах ёстой мэт санагддаг. Гэхдээ чамд санаа тавьдаг, чамд туслахыг хүсдэг хүмүүс бий гэдгийг санаж, тэдэнтэй ярилцаарай.

- **Найз нөхөд** чинь чиний зургийг цааш нь түгээхээс татгалзаж, чамайг дооглож, доромжлохгүйгээр чиний төлөө зогсож чадна.
- **Чиний итгэлийг даасан том хүн** асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө өгч, гомдол гаргахад болон бусад төвөгтэй зүйлсийг шийдвэрлэхэд тусалж чадна. Итгэлийг чинь даасан том хүн гэдэг нь аав ээж, авга, нагац, сургуулийн нийгмийн ажилтан эсвэл итгэж ярилцдаг нэгэн гэхчлэн хэн ч байж болно.
- **Багш нар** сургуулийн дотоод дүрмийг сурагчдад сануулж, нэгнийгээ дээрлэх ба доромжлохыг зогсоосноор цаашид учирч болох аливаа дээрлэлтээс сэргийлж болно.
- Сургуулийн захиргаа дээрлэлтэй холбоотой асуудлыг үл тоож, арга хэмжээ авахгүй байвал эцэг, эх, асран хамгаалагчдаа хандан багш болон сургуулийн ажилдыг чиний хэрэгт хандуулж өгхийг гуйгаарай.

ХҮЧТЭЙ БАЙГААРАЙ!

Хэний ч хувьд биеийн далд хэсэг нь ил гарсан дүрс бичлэг, зураг цахим орчинд тархана гэдэг үнэхээр онцгүй явдал. Энэ асуудал бидний сэтгэлийг өвтгөж, өөрсдийгөө бусдаас тусгаарлахад хүргэдэг. Гэхдээ чи ганцаараа ийм асуудалтай нүүр тулж байгаа биш шүү. **Чамтай яг адилхан нөхцөл байдалд орж, асуудлаа шийдвэрлэж, даван туулж чадсан олон хүүхдүүд байгааг санаарай.**

Чамаар ийм үйлдэл гаргуулж, ашигласан хүмүүс чамайг сул дорой болгохыг хүсэж байгаа. **Гэхдээ чи сул дорой биш** харин ч хүчирхэг нэгэн. Тиймээс нөхцөл байдал болон өөрийн амьдралыг гартаа бүрэн авч чадна.

ХЭРЭВ НАМАЙГ ЗАНАЛХИЙЛЖ, СҮРДҮҮЛСЭН ЗУРВАС ИРВЭЛ БИ ЯАХ ВЭ?

Хэн нэгнээс биднийг сүрдүүлж, заналхийлсэн зурвас ирвэл, жишээлбэл, өсвөр насны хүүхэд өөрийн биеийн далд хэсгийг харуулсан зураг, дүрсийг итгэдэг найз нөхөд рүүгээ явуултал дахиад ийм төрлийн зураг явуулахыг шаардаж, үгүй бол зургийг чинь аав, ээж рүү чинь илгээн хэмээн сүрдүүлж, заналхийлбэл яах вэ?

Ийм нөхцөл байдалд орсон нэгэн хийсэн үйлдэлдээ гэмшиж, тэдний хүссэнийг нь биелүүлэхээс өөр аргагүй мэт санагдаж мэднэ. Гэхдээ энэ бол **БУРУУ** шийдвэр. Цахим сүрдүүлэг бол хууль бус үйлдэл бөгөөд тэдний шаардлагыг биелүүлэх хэрэггүй.

Харин оронд нь:

- Сүрдүүлэгчээс бүх харилцаагаа таслаарай. Тэд чамтай харилцсан чатаа ашиглан чамайг сүрдүүлж, заналхийлэх гэж хичээх болно. Тэгсэн ч тэдэнд ямар ч боломж бүү өг. Тэдэнтэй харилцсан хэвээр байгаа тохиолдолд ч харилцаагаа зогсоож, холбогдох газарт мэдээлэхэд хэзээ ч оройтохгүй.
- Өөрийн утасны жагсаалт болон цахим хаягаасаа тэднийг устгаж, блоклоорой. Хэрэв чи өөрийн цахим хаягийг идэвхгүй болгохыг хүсвэл тухайн сайт болон апп дээрх ТУСЛАМЖ цэсрүү хандаарай.
- Цагдаад мэдэгдэх эсвэл CyberTipline.org-руу цаг алдалгүй мэдэгдээрэй. Аль нь ч чамд туслах бөгөөд тухайн цахим сүрдүүлэгчтэй харилцсан зурвас чатуудыг нотлох баримт болгон холбогдох хүмүүст өгөххэрэгтэй.